

Өнгөний тайлбар:

Хассан

Нэмсэн

Тайлбар

“Аюулгүйн хамгаалалтын байдлын үндэсний хөтөлбөр”-ийн нэр томьёо

ИНД-140 болон ИНтХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд “Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөр” гэж орсон.

1. "агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын байдлын хөтөлбөр" гэж зөрчигч, агаарын хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээний ажилтан, түүнчлэн агаарын хөлгийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор үндэсний хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан агаарын тээвэрлэгч байгууллага, эсхүл түүний төлөөлөгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааг нарийвчлан төдөрхөйлсөн баримт бичгийг;

ИНД-ийн нэр томьёоны тайлбарт:

Агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр / Air operator security program гэж агаарын тээвэрлэгчийн зорчигч, багийн гишүүн, газрын ажилтан, агаарын хөлөг болон байгууламжийг хууль бус үйлдлээс хамгаалах хөтөлбөрийг;

ИНД-ийн нэр томьёоны тайлбар, ИНД-108, ИНД-119, ИНД-121, ИНД-125, ИНД-129, ИНД-13, ИНД-171, ИНД-172-т “агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр” гэж орсон.

2. “агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлс” гэж агаарын тээвэрлэгчийн дотоод үйл ажиллагаанд зориулагдсан өөрийн, эсхүл гэрээт байгууллагад хүргүүлэх зорилгоор тээвэрлэгдэх бичиг баримт, хангамжийн материал, техник үйлчилгээний сэлбэг, нислэгийн хөөл хүнс, цэвэрлэгээний болон бусад зүйлсийг;

ИНД-ийн нэр томьёоны тайлбарт:

Шуудангийн эд зүйл / Postal article гэж захидал, илгээмж, эсхүл дараах эд зүйлийг багтаасан, шуудангаар илгээсэн болон хүргэгдээгүй бусад эд зүйлийг (ИНД-92):

(1) хүргэсэн боловч, хүлээн авагчийн гарт очоогүй эд зүйл;

(2) захидал, илгээмж, эсхүл эд зүйлийн агууламж;

3. "агаарын хөлгийн аюулгүйн байдлын үзлэг" гэж зөрчигч авч нэвтрэх сэжигтэй зүйлс, зэвсэг, тэсрэх бодис эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор талд хийх үзлэгийг;

ИНД-ийн нэр томьёоны тайлбарт:

Аюулгүйн үзлэг / Screening гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай төхөөрөмж, эд зүйл, эсхүл бодисыг техник, төхөөрөмж ашиглан, эсхүл бусад арга хэлбэрээр илрүүлэх ажиллагааг;

4. "агаарын хөлгийн аюулгүй байдлын шалгалт" гэж сэжигтэй зүйлс, зэвсэг, тэсрэх бодис эсхүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор болон гадна талд хийх шалгалтыг; ИНД-140 Хавсралт А.3. “Агаарын хөлгийн шалгалт” зүйлээс авч, дахин боловсруулах шаардлагатай.

5. "анкет шалгах" гэж дотоодын хууль тогтоомжийн дагуу тухайн хүний тохирох эсэхийг үнэлэхтэй холбогдуулан уг хүний биеийн байцаалт болон өмнөх туршлага, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, аюулгүйн хамгаалалттай байдалтай холбоотой бусад мэдээллийг шалгахыг; ИНД-140 Хавсралт А.15. "Нэвтрэх үнэмлэх болон зөвшөөрлийг шалгаж бататгах" зүйлээс авч, дахин боловсруулах шаардлагатай.

6. "аюулгүйн хамгаалалт байдал" гэж ~~иргэний нисэхийг хүний болон материаллаг нөөцийг хослуулах замаар хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахыг~~; ИНД-ийн нэр томъёоны тайлбар болон ИНТХ-ийн төсөлд дараах байдлаар орсон.

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Нисэхийн аюулгүйн хамгаалалт / Aviation security гэж хүний нөөц болон материаллаг эх үүсвэрийг хослуулах замаар иргэний нисэхийг хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээг;

7. "аюулгүйн хамгаалалтын байдлын аудит" гэж үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх шалгалтыг;

8. "аюулгүйн хамгаалалтын байдлын хяналт" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис эсхүл аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг;

9. "аюулгүйн байдлын үзлэг" гэж ~~хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис эхсүл бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс болон бодисыг илрүүлэхэд чиглэсэн техникийн болон бусад арга хэрэгслээр хийх үзлэгийг~~; 3 дугаартай давхардаж байна.

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Аюулгүйн үзлэг / Screening гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай төхөөрөмж, эд зүйл, эсхүл бодисыг техник, төхөөрөмж ашиглан, эсхүл бусад арга хэлбэрээр илрүүлэх ажиллагааг;

10. "аюулгүйн үзлэгийн байдлын сорилт" гэж хөндлөнгийн хууль бус үйлдлийн хэлбэрээр нисэхийн аюулгүйн хамгаалалтын байдлын үйл ажиллагааг ил болон далд шалгахыг; ИНД-140 Хавсралт А.24. "Давтан сорилт хийх" зүйлээс авч, дахин боловсруулах шаардлагатай.

11. "дамжин өнгөрөх зорчигч" гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөрөө нислэгээ цааш үргэлжлүүлж байгаа зорчигчийг;

12. "дамжин өнгөрөх тээш" гэж ~~тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөс буулгалгүй цааш үргэлжлүүлэн тээвэрлэх тээшийг~~;

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Дамжин өнгөрөх тээш / Transit baggage гэж;

(1) аэродромд агаарын хөлөг ирэхэд түүний бүхээгт байсан;

(2) тухайн аэродромыг агаарын хөлөг орхиход бүхээгт байсаар байгаа тээшийг;

13. "дипломат тээш болон илгээмж" гэж Дипломат харилцааны тухай 1961 оны Венын конвенцийн Зүйл 27.7 ~~хөтнөө батлагдсан~~ болон Консулын харилцааны тухай 1963 оны Венын ~~д батлагдсан~~ конвенцийн Зүйл 35.7-ын дагуу тээвэрлэгдэх дипломат шуудан болон материалыг;

14. "нийтийн эзэмшлийн бүс" гэж ямар нэг зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй орж гарч болох нисэх буудлын барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

15. "нислэгийн аюулгүйн хамгаалалтын байдлын ажилтан / sky marshal" гэж агаарын тээвэрлэгч, эсхүл ийн түүний харьяалах улсын Засгийн газраас ~~эрх-өлгөгдсөн-бөхөн агаарын хөлгийн бүртгэлтэй-улсын Засгийн газраас~~ тухайн агаарын хөлөг, ба түүний бүхээгт дөтөр байгаа хүмүүсийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахаар томилогдсон этгээдийг өйлгөнө. ~~Агаарын хөлөгт нэг буюу хэсэг хүмүүсийг тусгайлан хамгаалахаар томилогдсон этгээд, тухайлбал хувийн бие хамгаалагчийг үүнд хамааруулахгүй.~~

16. "нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын байдлын хороо" гэж нисэхийн аюулгүйн хамгаалалтыг байдлыг хангах болон үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх ажилтан аюулгүйн хамгаалалтын мэдлэг чадвараа дээшлүүлэх хангалттай мэдээлэлтэй байгааг бататгах зорилготой нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын байдал хариуцсан албан тушаалтанд зөвлөгөө өгөх хороог; ИНД-140 Хавсралт А.21-д нийцүүлэн, засах шаардлагатай.

17. "нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байдлын үүрэг хүлээсэн байгууллага" гэж Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын байдлын үндэсний хөтөлбөрийг ~~бөлөвөрүүлэх, өөрчлөх санал гаргах,~~ хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагыг;

18. "нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын байдлын хөтөлбөр" гэж ~~хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор үндэсний хөтөлбөрийн шаардлагад нийцүүлэн бөлөвөрүүлсэн нисэх буудалд хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааг нарийвчлан төдөрхөйлсөн баримт бичгийг;~~ Тусдаа ийм хөтөлбөр байх шаардлагагүй, үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.

19. "Бүхээгийн хэрэглээний нөөц (хангалт) нислэгийн үед хэрэглэгдэх эд зүйлс" гэж нислэгийн үед зорчигчийн үйлчилгээнд хэрэглэх, эсхүл худалдах эд зүйлсийг;
AC01-0 Annex definitions and abbreviations:

Бүхээгийн хэрэглээний нөөц (хангалт) / Stores (Supplies) for consumption гэж Агаарын хөлгийн зорчигч, нисэх багийн гишүүдийн үйлчилгээнд зориулан хэрэглэх, эсхүл борлуулах бараа болон агаарын хөлгийн техник үйлчилгээнд шаардлагатай бараа, түүнчлэн шатахуун, тослох материалыг;

20. "онцгой анхаарлын цэг" гэж ~~гэмтсэн болон устгагдсаны улмаас~~ иргэний нисэхийн үйл ажиллагаанд ноцтой саад учруулж болзошгүй нисэх буудлын ~~аэродромын гэмтсэн болон устсан~~ барилга байгууламж, ~~төног~~ төхөөрөмжийг;

21. "тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа нислэг" гэж хөдөө аж ахуй, барилга байгууламж, зураг авах, хайгуул, ажиглалт, эргүүл, эрэн хайх, авран туслах, зар сурталчилгаа зэрэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор гүйцэтгэж байгаа нислэгийг; ИНД-ийн нэр томъёоны тайлбар болон ИНтХ-ийн төсөлд дараах байдлаар тусгагдсан тул энд тусад нь оруулах шаардлагагүй.

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Тусгай зориулалтын нисэхийн үйл ажиллагаа / Special operation гэж агаараар зорчигч, эсхүл барааг хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх дараах үйл ажиллагааг:

(1) дараах:

(i) зорчигч бүр нь тухайн үйл ажиллагаанд тодорхой ажил, эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа, эсхүл ажил, үүрэг гүйцэтгэх сургалт хийж байгаа; эсхүл

(ii) бөглүү аэродроомоос, эсхүл бөглүү аэродром руу зорчигч, эсхүл бараа тээвэрлэж байгаа;

(2) (1)-д зааснаас бусад дараах үйл ажиллагаа:

(i) ИНД-133-ын дагуу гүйцэтгэдэг нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа; эсхүл

(ii) ИНД-137-ийн дагуу гүйцэтгэдэг хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа;

22. "тэсрэх бөмбөгөөр заналхийлэх" гэж нислэг үйлдэж байгаа, эсхүл газарт байгаа агаарын хөлөгийн аюулгүй—байдал—болон нисэх буудал, иргэний нисэхийн байгууламжид, хувь—хүнд эсхүл тэдгээрийн ойролцоо тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглан ийн аюул учруулж ч болзошгүй талаар эзэнтэй, эсхүл эзэнгүй, үнэн, эсхүл худал мэдээллээр заналхийлэхийг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

Аюул заналхийлэл / Threat гэж ажилтнаас хамааралгүй гардаг, үйл ажиллагааны төвөгшлийг нэмэгдүүлдэг бөгөөд аюулгүйн хамгаалалтын түвшнийг хадгалахын тулд заавал удирдаж, хянадаг байх шаардлагатай тохиолдол, эсхүл алдаа (AN 1)

Аюул заналхийллийн удирдлага / Threat management гэж Хүсээгүй төлөв байдал, эсхүл алдаа гарах магадлалыг багасгах болон заналхийллийн үр дагаврыг бууруулах, эсхүл арилгах сөрөг арга хэмжээ бүхий заналхийллийг илрүүлэх, хариу үйлдэл хийх үйл явц (AN 1)

23. "тээш ялгах талбай" гэж тээвэрлэх тээшийг аяллын дугаар, чиглэлээр нь ялгах талбайг;

24. "үйлчилгээнд гарсан агаарын хөлөг" гэж нислэгт бэлэн болох нь баталгаажсан, тухайн аяллын дугаар олгогдсон болон зорчигчийг хүлээн авах зохих бэлтгэл хангагдан, агаарын хөлгийн диспетчерийн хяналтад орсон, зогсоолд байрласан агаарын хөлгийг;

25. "үзлэгийн дараах бүс" гэж аюулгүйн хамгаалалтын байдлын үзлэгийн цэг болон агаарын хөлгийн хоорондох хэсгийг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

Үзлэгийн дараах бүс / Sterile area гэж Тухайн бүсэд нэвтрэх хяналт дээр нэмж аюулгүйн хамгаалалтын бусад хяналтыг хийдэг өндөр эрсдэлтэй бүс гэж тогтоосон нисэх буудлын хамгаалалттай бүсийн талбай; Энэ бүс нь аюулгүйн үзлэгийн цэгээс, нислэгт бэлтгэж агаарын хөлөг болон аюулгүйн үзлэг хийсэн ачаа, тээш байрласан ачааны талбай, шуудангийн төв, хамгаалалттай бүс дэх катеринг болон агаарын хөлгийн цэвэрлэгээний талбайг багтаасан агаарын хөлөг, зогсоол болон тээш бэлтгэх

талбай хүртэлх зорчих гудам, бүх арилжааны нислэгийн зорчигчийн явах бүсийг багтаана (AN 17)

26. "сэжигтэй хяналтгүй орхисон эд зүйлс" гэж эзэнгүй, эсхүл эзнийг нь тогтоох боломжгүй, аюул заналхийлэл агуулсан байж болзошгүй гэж—үзсэн сэжигтэй эд зүйлсийг;

27. "аюулгүйн хамгаалалттай хамгаалагдсан бүс" гэж аюулгүйн хамгаалалтын байдлын хяналт бүхий нисэх буудал, ын аэродромын талбай, барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс / Security enhanced area гэж Дарга хуулийн дагуу өндөржүүлсэн хамгаалалттай байхаар зарласан талбайг;

28. "хориотой бүс" гэж аюулгүйн хамгаалалтын байдлын үзлэгийн цэгээс агаарын хөлөг хүртэлх зорчигчдын танхим, тээш ялгах талбай, перрон, нислэгт бэлтгэгдсэн агаарын хөлөг, аюулгүй байдлын үзлэг хийгдсэн тээш, ачаа, шуудан болон хамгаалагдсан бүсэд байрлах нислэгийн хөөл хүнс бэлтгэх газар, цэвэрлэгээний талбай зэрэг илүү эрсдэлтэй гэж тодорхойлогдсон, нэмэлт нэвтрэх хяналт, бусад аюулгүй байдлын хяналт шаардлагатай хамгаалагдсан бүсийн хэсгийг; 25. "үзлэгийн дараах бүс"-тэй давхардаж байна. Бүсийг хамгаалалттай, эсхүл өндөржүүлсэн хамгаалалттай гэж хуваана. "Хориотой бүс" гэж ангилдаггүй тул "үзлэгийн дараах бүс" гэж оруулах. Жич: ХЗДХЯ-наас хуулиар хориглоогүй зүйлийг "хориглох, хориотой" гэсэн үгийг ашиглахгүй "зөвшөөрөгдөөгүй, хяналттай" зэрэг үг хэрэглэхийг зөвлөдөг.

AC01-0 Annex definitions and abbreviations:

Үзлэгийн дараах бүс / Sterile area гэж Тухайн бүсэд нэвтрэх хяналт дээр нэмж аюулгүйн хамгаалалтын бусад хяналтыг хийдэг өндөр эрсдэлтэй бүс гэж тогтоосон нисэх буудлын хамгаалалттай бүсийн талбай; Энэ бүс нь аюулгүйн үзлэгийн цэгээс, нислэгт бэлтгэж агаарын хөлөг болон аюулгүйн үзлэг хийсэн ачаа, тээш байрласан ачааны талбай, шуудангийн төв, хамгаалалттай бүс дэх катеринг болон агаарын хөлгийн цэвэрлэгээний талбайг багтаасан агаарын хөлөг, зогсоол болон тээш бэлтгэх талбай хүртэлх зорчих гудам, бүх арилжааны нислэгийн зорчигчийн явах бүсийг багтаана. (AN 17)

29. "хориглосон Зөвшөөрөгдөөгүй эд зүйлс" гэж агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон эсхүл зөвхөн тээвэрлэлтийн тусгай журмын дагуу тээвэрлэх хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эд зүйлсийг;

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Зөвшөөрөгдөөгүй эд зүйл / Unauthorised article гэж аливаа этгээд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр, эсхүл тухайн агаарын хөлгийн өмчлөгч, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн зөвшөөрөлгүй, эсхүл тухайн зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр агаарын хөлгийн бүхээгт авч орсон, эсхүл авч орохыг завдсан дараах эд зүйлийг (ИНД-140):

(1)галт зэвсэг; эсхүл

(2)бусад аюултай, эсхүл хор хөнөөл учруулах зэвсэг, эсхүл эдгээрийн аливаа төрлийн хэрэгсэл; эсхүл

(3)сум хэрэгсэл; эсхүл

(4)тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл бусад гэмтэл учруулах бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл түүний бүхээгт байгаа этгээдийн аюулгүй байдалд аюул учруулахад ашиглах аливаа төрлийн хэрэгсэл;

30. ~~"хөндлөнгийн хууль бус үйлдэл" гэж иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад байдалд нөлөөлөх дараах үйлдэл эсхүл оролдлогыг:~~

- ~~— агаарын хөлгийг хууль бусаар булаан эзлэх;~~
- ~~— үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг устгах;~~
- ~~— агаарын хөлөгт болон нисэх буудалд хүн барьцаалах;~~
- ~~— агаарын хөлөг, нисэх буудлын хамгаалагдсан бүс болон агаарын навигацгийн тэнгэр төхөөрөмж, байгууламжид хүч түрэмгийлэн нэвтрэх;~~
- ~~— гэмт хэрэг үйлдэх зорилгоор агаарын хөлгийн бүхээгт, нисэх буудалд зэвсэг эсхүл аюултай хэрэгсэл болон эд зүйлсийг нэвтрүүлэх;~~
- ~~— үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг хүний амь нас, эрүүл мэндэд нөцтэй гэмтэл учруулах буюу үхэлд хүргэх эсхүл эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд нөцтэй хохирол учруулах зорилгоор ашиглах;~~
- ~~— нислэг үйлдэж буй эсхүл газарт байгаа агаарын хөлгийн аюулгүй байдал ажиллагаа, нисэх буудал, түүний барилга байгууламж дахь зорчигч, нисэх багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан болон иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээ, мэдээллийг тараах;~~

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Хууль бус үйлдэл / Acts of unlawful interference гэж зорчигч, багийн гишүүн, газрын ажилтан, агаарын хөлөг, эсхүл байгууламжид аюул учруулах үйлдэл, эсхүл завдсан үйлдлийг;

31. ~~"нийтийн хэв журам зөрчсөн зорчигч" гэж нисэх буудал, агаарын хөлгийн бүхээгт хууль тогтоомж зөрчсөн эсхүл нисэх буудлын ажилтан, нисэх багийн гишүүдийн зааварчилгааг үл даган нисэх буудал болон агаарын хөлгийн хэвийн ажиллагааг алдагдуулж буй этгээдийг;~~

AC01-0 Annex definitions and abbreviations болон ИНД-13-т (шинэчлэгдэж байгаа):

Хэв журам зөрчсөн зорчигч / Unruly passenger гэж агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүн, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулсан, эсхүл учруулахаар завдсан, эсхүл агаарын хөлөг дотор санаатайгаар нийтийн хэв журам зөрчсөн этгээдийг;

32. "шилжүүлэн ачих ачаа ба шуудан" гэж тээвэрлэгдэж ирсэн агаарын хөлгөөс өөр агаарын хөлөгт шилжүүлэн ачих ачаа ба шууданг;

33. "шилжин ачигдах тээш" гэж агаарын хөлгөөр тээвэрлэгдэн ирж өөр агаарын хөлөгт шилжүүлэн ачих хүртэл хориотой бүсэд хадгалах тээшийг;

34. "шилжин суух зорчигч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу нислэгээ үргэлжлүүлэхийн тулд нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөгт шилжин сууж байгаа зорчигчийг;

35. "шуудан" гэж Дэлхийн шуудангийн холбооны дүрмийн дагуу шуудангийн байгууллагад хүргэгдэх захидал үйлчилгээгээр явуулдаг, эсхүл түүнд хүргүүлдэг илгээмж болон бусад зүйлсийг;

ИНД-ийн нэр томъёоны тайлбар:

Шуудан / Mail гэж шуудан зөөгч, шуудангийн оператор, эсхүл шуудангийн бусад байгууллага, эсхүл дипломат байгууллагаар дамжин хүргэгдэх захидал, боодол, илгээмж, ил захидал, эсхүл бусад эд зүйлийг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

Шуудан / Mail гэж Дэлхийн шуудангийн холбооны (UPU) дүрмийн дагуу шуудангийн үйлчилгээгээр явуулдаг, эсхүл түүнд хүргүүлдэг илгээмж болон бусад зүйлсийн хүргэлт (AN 9)

36. ~~"эзэн нь тогтоогдоогүй Нэхэмжлээгүй тээш"~~ гэж нисэх буудалд тээвэрлэгдэж ирсэн, зорчигч өөрийн гэж мэдүүлээгүй тээшийг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

Нэхэмжлээгүй тээш / Unclaimed baggage гэж нисэх буудалд ирсэн боловч зорчигч аваагүй, эсхүл нэхэмжлээгүй тээш (AN 9)

37. ~~"эзэнгүй Танигдаагүй тээш"~~ гэж тээшний эүүлттэй буюу эүүлтгүй, эзэн нь тогтоогдоогүй тээшийг;

AC01-0 Annex definitions and abbreviations:

Танигдаагүй тээш / Unidentified baggage гэж нисэх буудалд зорчигч аваагүй, эсхүл таниагүй ба тээшний шошготой, эсхүл шошгогүй тээш (AN 9; AN 17)

38. ~~"зохицуулалттай агаарын ачааны зуучлалын байгууллага"~~ гэж ачаа, шуудантай хөлбоотой нислэгийн аюулгүй байдлын үүрэг хүлээсэн байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн агаарын тээвэрлэгчтэй хамтран үйл ажиллагаа явуулдаг бөгөөд аюулгүй байдлын хяналтыг хангадаг хуулийн этгээд, тээвэр зууч болон бусад байгууллагыг;

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Зохицуулалттай агаарын ачааны байгууллага / Regulated air cargo agent гэж ИНД-109-ийн дагуу олгосон, зохицуулалттай агаарын ачааны байгууллагын гэрчилгээ эзэмшигчийг;

39. ~~"аюулгүйн байдлын үзлэг шалгалт"~~ гэж эрх бүхий байгууллагаас нисэх буудал, агаарын тээвэрлэгч, иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын байдлын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага болон бусад байгууллага Үндэсний хөтөлбөрт заасан аюулгүйн хамгаалалтын байдлын шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих үйл ажиллагааг; 3, 9 дугаартай давхардаж байна.

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Аюулгүйн үзлэг / Screening гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис, эсхүл бусад аюултай төхөөрөмж, эд зүйл, эсхүл бодисыг техник, төхөөрөмж ашиглан, эсхүл бусад арга хэлбэрээр илрүүлэх ажиллагааг;

40. ~~"үнэмлэхжүүлэлт"~~ гэж нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байдлын үүрэг хүлээсэн байгууллагаас тухайн этгээд зохих түвшинд өөрийн үүргийг гүйцэтгэх чадвартайг үнэлж, албан ёсоор баталгаажуулах үйл ажиллагааг;

41. ~~"тогтмол илгээгч бүртгэлтэй харилцагч"~~ гэж аюулгүйн хамгаалалтын байдлын дүрэм, журам, стандартад нийцүүлэн ачаа, эсхүл шууданг бүх төрлийн агаарын хөлгөөр тээвэрлүүлэхээр тогтмол илгээдэг ж-байгаа этгээдийг; ИНД-109.61, 103-т нийцүүлэх

42. ~~"өндөр эрсдэлтэй гэмтэл учирсан ачаа, шуудан / tampered goods"~~ гэж тагнан турших үйл ажиллагааны үзлэг шалгалтын үр дүнд иргэний нисэхийн нислэгийн үйл ажиллагаанд заналхийлэл аюул учруулж болзошгүй гэж үзэх сэн сэжигтэй төрүүлэхүйц хэвийн бус, эсхүл баглаа боодол нь хөндөгдсөн шинжтэй ачаа, шууданг; ИНД-109-д нийцүүлэх

43. ~~“арилжааны агаарын тээвэр” гэж зорчигч, ачаа, тээш, шууданг агаарын хөлгөөр төлбөртэйгээр тээвэрлэх үйл ажиллагааг;~~

ИНД-ийн нэр томъёоны тайлбарт:

Арилжааны нислэгийн үйл ажиллагаа / Air operation гэж зорчигч, эсхүл барааг агаараар хөлс, эсхүл шан урамшуулалтай тээвэрлэх үйл ажиллагааг;

44. ~~“урьдчилан тааварлах боломжгүй байдал”~~ Аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг” гэж аюулгүйн хамгаалалтын ~~байдлыг хангах~~ арга хэмжээний үр дүн, ~~үр нөлөөг нэмэгдүүлэх бататгах~~ зорилгоор ~~гэнэтийн хяналт~~ шалгалтыг тогтмол бус давтамжтайгаар өөр өөр байршилд, эсхүл өөр арга хэрэгсэл ашиглан хэрэгжүүлэх арга хэмжээг; ИНД-140 Хавсралт А.14 “Аюулгүйн хамгаалалтын гэнэтийн сонгох үзлэг”-т нийцүүлэх

45. ~~“зан байдлыг таньж тогтоох” гэж иргэний нисэхэд заналхийлэл учруулж болзошгүй этгээдийг биеийн хэл, дохио зангаа зэрэг зан байдлын хэвийн бус шинжээр нь таних арга барил ашиглан илрүүлэхийг.~~

AC01-0 Annex definitions and abbreviations:

Зан төлөвийг тодорхойлох / Behaviour detection гэж Нисэхийн аюулгүйн хамгаалалтын хүрээнд иргэний нисэхэд аюул заналхийлэл учруулж болзошгүй этгээдийг таньж тогтоох зорилгоор физиологийн, эсхүл гар, биеийн хөдөлгөөний эрүүл бус төлөвийг багтаасан, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй зан төлөвийг тодорхойлоход ашигладаг арга техникийг (AN 17)